

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ЖУРАМ**Баримт бичгийн мэдээлэл**

Баримт бичгийн дугаар:	ЖР-ТУЗ-007 /ТУЗ-ийн хурлын 23/12/20-ны өдрийн 23/0/г тоот тогтоолын Хавсралт 1/
Баримт бичгийн хувилбарын дугаар:	1.0
Хүчин төгөлдөр болсон огноо:	2023/12/20
Мэдээллийн ангилал:	Нийтэд хүртээмжтэй
Мэдээллийн түвшин:	3
Хариуцагч:	ТУЗ-ийн дарга
Хэрэглэгч:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, үйлчилгээний ажилтнууд

	Овог нэр	Албан тушаал	Гарын усэг
Баталсан:	Г.Хатанболд	ТУЗ-ийн дарга	
Боловсруулсан:	Ч.Жаргал	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	

Өөрчлөлтийн түүх

Хувилбарын №	Огноо	Боловсруулсан	Өөрчлөлтийн тайлбар	Хянасан	Баталсан
1.0	2023/12/20	Ч.Жаргал	Анхны хувилбар	ТҮЗ-ийн гишүүд	Г.Хатанболд

Түгээлт

Тайлбар

Айтүүлс ХК-ийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигч, олон нийтэд нээлттэй түгээгдэнэ.
Энэхүү баримт бичгийг хувилбарын дугаараар хянана.

ГАРЧИГ

1.	Нийтлэг үндэслэл	4
2.	Хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээлэл	4
3.	Хөрөнгө оруулагчидтай харилцах.....	4
4.	Хөрөнгө оруулагчдын санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх	5
5.	Бусад.....	5

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн үйл ажиллагаа, хувьцааны үнэ ханшид нөлөөлж болохуйц үйл явдал, стратегийн зорилтын хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл, засаглалтай холбоотой мэдээллийг цаг тухайд нь хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрэхийг зорино. Үүнд:
 - 1.2.1. Компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын ил тод, нээлттэй байдлыг олон улсын сайн жишигт хүргэж, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах;
 - 1.2.2. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх;
 - 1.2.3. Компанийн зах зээлийн үнэлгээ бодитоор тогтох буюу компанийн хувьцааны ханшиг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангах;
 - 1.2.4. Ирээдүйн хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн үнэ цэнэ болон компанийн засаглалыг сайжруулах.

2. Хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээлэл

- 2.1. Компани нь хөрөнгө оруулагчдад дор дурдсан мэдээллийг компанийн цахим хуудас, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, тухайн хөрөнгө оруулагчид саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр холбогдох хууль, журамд заасан хугацаанд хүргэнэ. Үүнд:
 - 2.1.1. Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
 - 2.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;
 - 2.1.3. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой тухай бүр хүргэх мэдээлэл;
 - 2.1.4. Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;
 - 2.1.5. Хөрөнгө оруулагчдын санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байдал;
 - 2.1.6. Шаардлагатай бусад мэдээлэл.
- 2.2. Хугацаат тайлагнал, болон тухай бүр мэдээлэх мэдээллийг компанийн “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын дагуу хөрөнгө оруулагчдад мэдээлж, олон нийтэд нээлттэй болгоно.

3. Хөрөнгө оруулагчидтай харилцах

- 3.1. Компани нь дор дурдсан хэлбэрээр хөрөнгө оруулагчидтай харилцана. Үүнд:
 - 3.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн санхүүгийн гүйцэтгэл, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын тайлан болон хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулах;
 - 3.1.2. Цахимаар (и-мэйл, онлайн чат, фэйсбууц чат) болон биечлэн санал бодол, гомдлыг хүлээн авах;
 - 3.1.3. Цахимаар (и-мэйл, онлайн чат, фэйсбууц чат) болон биечлэн мэдээлэл хүргэх, солилцох;
 - 3.1.4. Компанийн утас, албан тоот, чат зэрэг бусад арга хэрэгсэл.
- 3.2. Компани нь холбогдох хууль, дотоод журмаар нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичиг, мэдээлэлтэй танилцах боломжийг хөрөнгө оруулагчдад олгоно.

- 3.3. Компанийн цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээлэл болон "Компанийн засаглалын кодекс"-т заасан бодлогын баримт бичгүүд, дотоод дүрэм, журам, зааврыг байршуулж, цаг тухайд нь шинэчлэн, хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудыг мэдээллээр хангана.
- 4. Хөрөнгө оруулагчдын санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх**
 - 4.1. Хөрөнгө оруулагчид ажлын цагаар дорх сувгуудаар дамжуулан хүсэлт, санал, гомдлоо компанид гаргаж болно. Үүнд:
 - 4.1.1. Биечлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр, эсхүл хэдийд ч компанийн байранд ирж, бичгээр санал гомдлоо илэрхийлэх;
 - 4.1.2. Компанийн 7575-5585 дугаартай лавлах утсаар;
 - 4.1.3. secretary@itoools.mn, info@itoools.mn и-мэйл хаягаар;
 - 4.1.4. Чатаар www.itoools.mn, www.facebook.com/itoools.mn;
 - 4.1.5. Компанийн хаягаар (УБ хот, СБД, 1-р хороо, Олимп-16, Реженси резиденс, 201 тоот) албан тоот ирүүлэх.
 - 4.2. Дээрх сувгуудаар ирсэн хөрөнгө оруулагчдын санал гомдлыг хүлээн авсан компанийн ажилтан нь санал гомдлыг бүртгэж, тухай бүр компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад шилжүүлнэ.
 - 4.3. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хөрөнгө оруулагчдын санал гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэх боломжийг судлан, ТУЗ-ийн даргад мэдэгдэж, шаардлагатай бол компанийн холбогдох албан тушаалтантай хамтран холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэнэ.
 - 4.4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хүсэлт, санал, гомдлыг нь биелүүлэх боломжтой, боломжгүй талаар, боломжгүй бол шалтгаан, боломжтой бол авсан арга хэмжээ, эсхүл шийдвэрлэж буй явцын талаар хөрөнгө оруулагчид ажлын 10 хоногийн дотор хариу өгч, түүний и-мэйл, цахим хаягт бичгээр мэдэгдэнэ.
 - 4.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хөрөнгө оруулагчийн хүсэлт, санал, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн саналыг дамжуулсан ажилтанд мэдэгдснээр ажилтан бүртгэж, асуудлыг хаана.
 - 4.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хөрөнгө оруулагчдаас ирсэн хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн хуралд танилцуулна.
- 5. Бусад**
 - 5.1. Энэхүү журам нь ТУЗ-ийн баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгднө.
 - 5.2. Энэ журмын хэрэгжилтэд ТУЗ-ийн дарга хяналт тавина.
 - 5.3. Компани болон хөрөнгө оруулагчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд аль болох эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
 - 5.4. Шаардлагатай гэж үзвэл энэ журамд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг ТУЗ-өөс шийдвэрлэнэ.